



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/308.

Улаанбаатар хот

Ойн хөнөөлт шавж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх арга хэмжээний ажлын зардлын хуваарь баталж, эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.4 дэх хэсэг, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2.1, Ойн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.17, 13.1.23, 27 дугаар зүйлийн 27.2, "Хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай" Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 200 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ойн хөнөөлт шавж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх арга хэмжээний ажлын зардлын хуваарь, шаардагдах 3,480,400,000.00 /гурван тэрбум дөрвөн зуун наян сая дөрвөн зуун мянга/ төгрөгийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хавсралтаар баталсан Ойн хөнөөлт шавж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх арга хэмжээний зардлыг зарцуулах эрхийг тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, "Ойн судалгаа, хөгжлийн төв" Улсын төсөвт үйлдвэрийн газар /Б.Мөнхбат/-т шилжүүлсүгэй.

3. Холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, "Ойн судалгаа, хөгжлийн төв" Улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбат нарт тус тус даалгасугай.

4. Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Ойн бодлого зохицуулалтын газар /М.Тунгалаг/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Алтангэрэл/-т, ажлын гүйцэтгэлийг үндэслэж санхүүжилтийн хуваарийн дагуу хяналт тавьж ажиллахыг Санхүүгийн хэлтэс /Б.Нансалмаа/-т тус тус үүрэг болгосугай.

САЙД



Н.ЦЭРЭНБАТ

8	Ойн хөнөөлт шавжийн олшрол ихтэй Төв аймгийн Батсүмбэр сумын нутагт суурин цэг байгуулах	1 цэг	10,000.00	10,000.00	-
9	Ойн хөнөөлт шавжийн олшрол ихтэй Горхи-Тэрэлжийн БЦГ-т ойд суурин цэг байгуулах	1 цэг	10,000.00	10,000.00	-
10	Ойн хөнөөлт шавжийн олшрол ихтэй Нийслэлийн ногоон бүсийн ойд суурин цэг байгуулах	1 цэг	10,000.00	10,000.00	-
11	Ойн хөнөөлт шавжийн олшролыг тодорхойлох суурин цэгт мониторинг хийхэд шаардлагатай багаж худалдан авах	1 ком	10,000.00	10,000.00	
12	Хяналт, мониторинг хийх		20,000.00	20,000.00	-
	НИЙТ ДҮН		3,480,400.00	200,000.00	3,280,400.00

Ойн бодлого зохицуулалтын газар

Огноо 2024.09.10  
 Хяналт, мониторинг хийх  
 Хяналт, мониторинг хийх